



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар дөрөв ОНӨААТҮГ2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2024/68/НА-СТА-ОНА

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2024он</p>	<p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:Аккаунт траст аудит ХХК-ийн захирал П.Наранцэцэг Утас: 99130778 Цахим хаяг: acctrust.audit@gmail.com Ахлах аудитор Ч.Замбага Утас: 99127118 Аудитор: П.Саранчимэг Утас:89986879</p>
--------------------------------------------------------------------------------------------------------	------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------------

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г жорлус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024.03.15 № 470

танай _____-ны № _____-г

БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН НИЙТЛЭГ
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ГАЗАР ДӨРӨВ
ОНӨААТҮГ-ЫН ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ М.ЭНХТАЙВАН
ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар дөрөв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар дөрөв ОНӨААТҮГ-ын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Баянзүрх дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 72 дугаар тогтоолоор Нийтлэг үйлчилгээний газар дөрөв ОНӨААТҮГ-ыг татан буулгахаар шийдвэрлэсэн байна.Тогтоолын дагуу комисс томилогдон 2023 оны 10 дугаар сарын 26-ны өдөр тус ОНӨААТҮГ-ын хөрөнгийг тоолон хүлээн авч, үйл ажиллагааг зогсоосон байна.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлага болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд 6 зорилтын хүрээнд 45 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 97.8 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Балансын зүйл	Өмнөх он	Тайлан он
ХӨРӨНГӨ		
Эргэлтийн хөрөнгө		
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	8,035,502.21	595,370.98
Дансны авлага	2,608,540.60	1,764,026.79
Бусад авлага	50,174.46	-
Бараа материал	47,966,512.00	10,233,170.00
Урьдчилж төлсөн зардал тооцоо	5,881,579.73	5,881,579.73
Эргэлтийн хөрөнгийн дүн	64,542,309.00	18,474,147.50
Эргэлтийн бус хөрөнгө		
Үндсэн хөрөнгө	998,793,837.55	1,105,590,371.74
Биет бус хөрөнгө	33,833.34	33,833.34
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	998,827,670.89	1,105,624,205.08
НИЙТ ХӨРӨНГӨ	1,063,369,979.89	1,124,098,352.58
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
ӨР ТӨЛБӨР		
Богино хугацаат өр төлбөр		
Дансны өглөг	119,759,502.30	36,072,257.85
Татварын өр	44,321,434.80	101,436,134.19
НДШ-ийн өглөг	84,301,881.10	237,716,211.16
ҮЭ-ийн татварын өглөг	-	2,488,321.09
Урьдчилж орсон орлого	809,621,431.23	872,416,792.03
Богино хугацаат өр төлбөрийн дүн	1,058,004,249.43	1,250,129,716.32
Урт хугацаат өр төлбөр		
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
Өр төлбөрийн нийт дүн	1,058,004,249.43	1,250,129,716.32
Төрийн өмч	1,420,210.00	1,420,210.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	36,900,000.00	36,900,000.00
Хуримтлагдсан ашиг	(32,954,479.54)	(164,351,573.74)
Эздийн өмчийн дүн	5,365,730.46	(126,031,363.74)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	1,063,369,979.89	1,124,098,352.58

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	2,434,147,396.00	1,578,363,700.00
2	Борлуулалтын өртөг	2,275,580,115.35	1,877,060,473.28
3	Нийт ашиг (алдагдал)	158,567,280.65	(298,696,773.28)
6	Хүүгийн орлого	-	1,140,217.38
8	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	160,954,639.20
9	Бусад орлого	-	5,204,822.50
10	Борлуулалт, маркетингийн зардал	-	-
11	Ерөнхий ба удирдлагын зардал	216,267,784.90	-
12	Санхүүгийн зардал	1,600,000.00	-
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	(59,300,504.25)	(131,397,094.20)
20	Орлогын татварын зардал	-	-
21	Татварын дараах ашиг (алдагдал)	(59,300,504.25)	(131,397,094.20)
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	(59,300,504.25)	(131,397,094.20)
27	Бусад олз (гарз)	(15,281,572.92)	-
28	Орлогын нийт дүн	(74,582,077.17)	(131,397,094.20)

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Д/Д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,420,210.00	36,900,000.00	(16,972,402.37)	21,347,807.63
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга			58,600,000.00	58,600,000.00
3	Залруулсан үлдэгдэл	1,420,210.00	36,900,000.00	41,627,597.63	79,947,807.63
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(74,582,077.17)	(74,582,077.17)
9	2022 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,420,210.00	36,900,000.00	(32,954,479.54)	5,365,730.46
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга				-
11	Залруулсан үлдэгдэл	1,420,210.00	36,900,000.00	(32,954,479.54)	5,365,730.46
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			(131,397,094.20)	(131,397,094.20)
	2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	1,420,210.00	36,900,000.00	(164,351,573.74)	(126,031,363.74)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2022 оны 12-р сарын 31	2023 оны 12-р сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	2,345,464,444.00	1,584,713,917.38
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	70,834,300.00	
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, хүү, төлбөрийн орлого		1,140,217.38
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө		
1.1.4	Буцаан авсан албан татвар		
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	2,274,630,144.00	1,578,913,700.00
1.1.6	Бусад мөнгөн орлого		4,660,000.00
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	2,343,856,727.61	1,592,154,048.61
1.2.1	Ажиллагчдад төлсөн	886,172,146.30	781,722,711.50
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	234,998,018.36	65,000,000.00
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	312,948,036.00	131,145,000.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	13,239,845.20	4,599,665.17
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	574,379,620.00	483,108,838.00
1.2.6	Татварын байгууллагад төлсөн	82,635,820.00	11,000,000.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	239,483,241.75	115,577,833.94
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	1,607,716.39	(7,440,131.23)
2.00	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	21,250,400.00	-
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	21,250,400.00	
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(21,250,400.00)	-
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)	-	-
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	-	-
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-	-
5.00	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	(19,642,683.61)	(7,440,131.23)
6.00	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	27,678,185.82	8,035,502.21
7	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	8,035,502.21	595,370.98

Баянзүрх дүүргийн нийтлэг үйлчилгээний газар дөрөв ОНӨААТҮГ-ын
2023 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

3.АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт залруулагдаагүй 35,144.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 35,144.0 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тус ОНӨААТҮГ-ын хөрөнгийг 2023.10.2-ны өдөр тоолж, тэмдэглэл үйлдсэн байна. Тэмдэглэлд 200.0 мянган төгрөгийн түлш шатахууны үлдэгдлийг хэмжилт хийж хүлээн аваагүй, 4,425.1 мянган төгрөгийн 2 ширхэг хөрөнгө дутагдсан гэсэн байх боловч холбогдох шийдвэрийг гаргаагүй, эздээр нь төлүүлэх арга хэмжээ аваагүй, санхүүгийн тайланд тусгаагүй байна.	1	4,425.1			-	-	1	4,425.1	-	-	-	-
Авлага дансанд хувь хүнээс авах 1,764.0 мянган төгрөг, урьдчилгаа дансанд цалингийн урьдчилгаа 5,881.6 мянган төгрөг, нийт 7,645.6 мянган төгрөгийн авлага, өглөг дансанд түрээсийн төлбөр, бусад зардлын 24,546.8 мянга, байгууллага, хувь хүмүүст өгөх 11,525.8 мянга, нийт 36,072.2 мянган төгрөгийн өглөг бүртгэлтэй байгааг тооцоо нийлж баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй, ажилчидтай холбоотой нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын татвар, үйлдвэрчний эвлэлийн татварын нийт 341,640.7 мянган төгрөгийг төлөөгүй байна.	1	-	-	-	-	-	1	-	-	-	-	-
Тайлант онд худалдан авсан бараа ажил үйлчилгээний 30,719.0 мянган төгрөгийн худалдан авалтын и баримт татварын цахим системд бүртгэгдээгүй байна.	1	30,718.9					1	30,718.9				
Дүн	3	35,144.0			-	-	3	35,144.0	-	-	-	-

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үлдэл.